

тушаалд квалификация өсгөдөг
2008



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 128

Улаанбаатар хот

Гадаадад зээлээр суралцуулах,
тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”, захиалагч байгууллагын саналыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хатанбаатар овогтой Төрболдыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар Австрали Улсын Southern Cross их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр, Хүрэлбаатар овогтой Лхагвасүрэнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар Австрали Улсын Charles Sturt их сургуулийн магистрантурт бизнесийн чиглэлээр тус тус 1,5 жилийн хугацаагаар 2008-2009 оны хичээлийн жилээс Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулсугай.

2. ОХУ-ын Дотоод явдлын яамны Дорнод сибирийн дээд сургуулийн адьюнктурт суралцаж буй Бор овогтой Машбат, ОХУ-ын Дотоод явдлын яамны Москвагийн их сургуулийн адьюнктурт суралцаж буй Доржсүрэн овогтой Нямдорж, ОХУ-ын Новосибирскийн Техникийн улсын их сургуулийн аспирантурт суралцаж буй Балжирсүрэн овогтой Ганцэцэг нарт эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлын зээл олгосугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 294 дүгээр тушаалын Барсүрэн овогтой Баасандоржтой холбогдолтой хэсгийн “Австрали Улсын Deakin их сургуулийн магистрантурт үндсэн хуулийн эрх зүйн чиглэлээр” гэснийг “АНУ-ын Калифорнийн улсын их сургуулийн магистрантурт улс төр судлалын чиглэлээр”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн 317 дугаар тушаалын Сүх овогтой Түмэнжаргалтай холбогдолтой хэсгийн “Нью Саут Вэйлс их сургуулийн” гэснийг “АНУ-ын Колорадогийн улсын их сургуулийн” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу

суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасгай.



Ё.ОТГОНБАЯР